



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 227

Улаанбаатар хот

Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хувьцаа
эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт
оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ард даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнийг энэхүү тогтоолын хавсралтад дурдсанаар өөрчлөхийг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Ард даатгал” ХХК /Г.Цогбадрах/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2017 оны 11 дугаар сарын 27 өдрийн
227 тоот тогтоолын хавсралт



“АРД ДААТГАЛ” ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН БҮТЭЦ,
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эхний үлдэгдэл			Өөрчлөлт			Эцсийн үлдэгдэл		
		Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 2,345.0005 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг	Нэмэгдсэн	Хорогдсон	Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 2345.0005 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь
1	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	1,239,227	2,905,987,934.61	83.03%	153,310	359,512,026.65		1,392,537	3,265,499,961.26	93.30%
2	“Бьюо Планэт” ХХК	153,310	359,512,026.65	10.27%	(153,310)		(359,512,026.65)	-	-	-
3	“Энержи Интернэшнл капитал” ХХК	70,000	164,150,035.00	4.69%				70,000	164,150,035.00	4.69%
4	“Хөрөнгө оруулагч үндэстэн” ХК	30,000	70,350,015.00	2.01%				30,000	70,350,015.00	2.01%
	Нийт	1,492,537	3,500,000,011.26	100%		359,512,026.65	(359,512,026.65)	1,492,537	3,500,000,011.26	100%